



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ АЖ АХУЙН
НЭГЖ, ИРГЭДЭД

0617.02.00 № 02-01/602
танай _____ -ны № _____ -т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Уул уурхайн салбарын ажил олгогчид нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрддөггүй, тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангадаггүй, сургалтад хамрагдаагүй, мэргэжлийн бус хүн ажиллуулдаг, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангадаггүй, галын аюулгүй байдлыг хангаж ажилладаггүй зэрэг нийтлэг зөрчил илэрч байгаа нь осол гарахад нөлөөлж байна.

Иймд дараах хууль тогтоомжийн заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг мэдэгдэж байна.

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуульд заасны дагуу хөдөлмөрийн байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1,5 хувиас доошгүй хөрөнгийг төсөвлөж зарцуулах /“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 /... аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна./

2. Аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулах, аюулгүй ажиллагааны зааварчлага аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх / “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.8 /аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилгаа аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх/

3. Ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийж болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх /“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 28 дугаар

1150500854

зүйлийн 28.1.4 /ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх/

4. Галын аюулгүй байдлыг хангаж ажиллах / "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 13 дугаар зүйлд 13.1 /Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ/, 13. /Галын дохиолол болон гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрт байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, ажилтныг уг тоноглолыг ашиглаж сургасан байна/

5. Үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжид тавигдах шаардлагыг хангаж ажиллах /"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 /машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг (ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл) нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх/

6. Үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд харьяа дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын байгууллагад бичгээр болон утсаар яаралтай мэдэгдэж байх /Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 /Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг нуун дарагдуулахыг хориглоно./,

7. Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах

Мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээг аваагүй, хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй тохиолдолд "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 16 дугаар зүйл, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 36 дугаар зүйлийн холбогдох заалтуудын дагуу захиргааны арга хэмжээ авч ажиллахыг анхааруулж байна.



ДАРГА

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

НМХГ-ын даргын 2017.02.20-ны өдрийн
02-01/602 тоот мэдэгдлийн 1 дүгээр хавсралт



1. "НК" ХХК
2. "Хонгда интернэйшнл" ХХК
3. "Цагаан ташаа" ХХК
4. "Угалзан цамхаг" ХХК
5. "Төгс эрхэс" ХХК
6. "Гүрэн" ХХК
7. "Хан Алтайн тоосго" ХХК
8. "Хэлтрэг" ХХК
9. "Хун Хуа" ХХК
10. "Күн Лүн"
11. "Хуалян" ХХК
12. "Зоогийн Их" ХХК
13. "Таван шүтээн" ХХК
14. "Орд трейд" ХХК
15. "Налайх од" ХХК
16. "Их урсгал" ХХК
17. "Хас Гуа" ХХК
18. "Гэрэлт орд" ХХК
19. "Баян эрдэнэ хүрд" ХХК